



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/244

Улаанбаатар хот

Жагсаалт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны "Журам батлах тухай" 246 дугаар тогтоол, Тагнуулын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Санал хүргүүлэх тухай" ТЕГ01/500 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг нэгдүгээр, Ашигт малтмал, газрын тосны газрын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хоёрдугаар, Үндэсний геологийн албаны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Б.Дашпүрэв), Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (П.Баянбаатар), Үндэсний геологийн албаны дарга (Н.Мөнхбилэг) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн "Жагсаалт шинэчлэн батлах тухай" А/169 дүгээр тушаал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн "Жагсаалтад нэмэлт оруулах тухай" А/248 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Г.ДАМДИННЯМ



Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
2025 оны /2 дугаар сарын /9-ны өдрийн
А/244 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМНЫ
АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН
ЖАГСААЛТ**

д/д	АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЭЛ
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон ажлын хэсгээс албаны нууцад хамаарах асуудлаар гаргасан тушаал, шийдвэр, хурлын тэмдэглэл болон бусад нууц тээгч
2	Онцгой байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
3	Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг
4	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлсийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээ, нотломж баримт бичиг, төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр
5	Байгууллага, харьяа байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай мэдээлэл
6	Төрийн болон албаны нууцын хамгаалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
2025 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн
А/244 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН
ЖАГСААЛТ

д/д	АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЭЛ
1	Ашигт малтмал, газрын тосны газрын албаны нууцад хамаарах асуудлаар гаргасан тушаал, бусад нуугч тээгч
2	Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
3	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг хэлэлцсэн, шилжүүлсэн шалгасан тухай мэдээ, нотломж баримт бичиг, төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр
4	Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, бусад нууц тээгч
5	Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг
6	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын
2025 оны 12 дугаар сарын 19 -ны өдрийн
А/... дугаар тушаалын гуравдугаар хавсралт
1/244



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН
ЖАГСААЛТ

д/д	АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЭЛ
1	Үндэсний геологийн албаны албаны нууцад хамаарах асуудлаар гаргасан тушаал, шийдвэр, төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг
2	Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө
3	Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлсийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээ, нотломж баримт бичиг, төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр
4	Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг
5	Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл